



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

ДОРЖЖАНЦАНГИЙН УЯНГА

**СУВИЛЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

E09170101 Уламжлалт Анагаах Ухаан

Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

**Улаанбаатар хот
2018 он**

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

ДОРЖЖАНЦАНГИЙН УЯНГА

**СУВИЛЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

АУ-ны доктор, дэд профессор Д.Зоригтбаатар

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

АУ-ны доктор, Д.Гантуяа

Улаанбаатар хот
2018

ТОВЧ ХУРААНГУЙ

СУВИЛЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Судалгааны ажлын үндэслэл: Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн статистик мэдээгээр рашаан сувиллаар үйлчлүүлэгчдийн тоо сүүлийн таван жилийн байдлаар 2011 онд 55359, 2012 онд 63240, 2013 онд 90801, 2014 онд 85225, 2015 онд 82996 үйлчлүүлэгчид үйлчлүүлсэн байдаг бөгөөд рашаан сувиллын тоо 2011 онд 67, 2012 онд 100, 2013 онд 71, 2014 онд 104, 2015 онд 105 сувилал үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс үзэхэд сувиллын байгууллагуудын тоо болон тэдгээрээр үйлчлүүлэгчдийн тоо өсөн, эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн нийтийн чиг хандлага нь өвчний дараах сэргээн засах эмчилгээ, эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэгдэж, ихэнх улс орнуудад рашаан сувилал, халамжийн үйлчилгээнд тулгуурилсан сэргээн засахын тусламж үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.

Монгол улс рашаан усаа шинжлэх ухааны үүднээс ашиглаж судалж ирсэн үеийг 1926-1927 оны үе гэж үздэг бөгөөд 1926 оноос газар зүй, геологийн судалгааны явцад зарим рашааныг зориуд судалж, судалгааг тодорхой чиглэлтэй хийж эхэлсэн.

1960 оноос хойш явуулсан судалгаагаар чиглэсэн зорилготой, тодорхой хөтөлбөртэй, хавсрага судалгааг төрөлжүүлж, мэдээлэл ашиглан манай үндэсний мэргэжилтнүүд бусад орны эрдэмтэд, судлаач нартай хамтарч Монгол орны нийт рашааны тархалт, химийн шинж чанар, найрлага, анагаах арга, ашиглах боломжийн ерөнхий тоймыг гаргаж, анхны бүдүүвчилсэн ангилалт, мужлалт хийснээс гадна рашаан сувиллын газрыг өргөтгөх, шинээр байгуулах талаар судалгаа шинжилгээ хийж ирсэн².

Засгийн газраас 1994-2002, 2002-2010 онд хэрэгжүүлсэн “Рашаан сувилал хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд зарим рашааны бүтэц найрлагыг нарийвчлан тогтоох, рашаан сувиллын ордыг паспортжуулах, бүс нутгийн хэмжээнд ашиглах рашааны ундаргыг судлан, рашаан усны нөөцийн судалгаа хийж рашааны ашиглалт, хамгаалалтын дүрмийг баталж мөрдүүлсэн байдаг.

Манай судлаачид рашаан усыг шинжлэх ухааны үүднээс рашааны эмнэлзүйн туршилт судалгаануудыг нэлээд явуулсан байна. Үүнд Шаргалжуутын рашаан, утлагын цагаан мөгөөрсөн хоолойн багтраа өвчний үед үзүүлэх нөлөөг Д.Бүрнээ (2006) нарын судлаачид эмнэл зүйн туршилт судалгаагаар нотолжээ. Ц.Ядамсүрэн,

Д.Цэвээндорж нарын судалгаагаар Аварга тосон нуурын ус, шавар нь арьсны зарим өвчнийг анагаах үйлдэлтэй болохыг тогтоосон байна. Д.Алимаа, Ж.Жамъяншарав (1981) нарын архаг ходоодтос өвчтэй хүмүүсийг Жанчивлин рашаанаар эмчилсэн судалгаагаар ходоодны шүүрэл дутагдалтай ходоодны архаг үрэвсэлтэй өвчний үед үр дүнтэй болох нь тогтоогдсон байна. Д.Зоригтбаатар (2011) нарын “Отгонтэнгэрийн рашаан эмчилгээний идэвхийн туршилт эмнэлзүйн судалгаа” сэдэвт бүтээлд Отгонтэнгэрийн рашаан нь ходоодны салст бүрхүүл болон элэгний эсийн гэмтлийг багасгах үйлдэлтэй болох нь тогтоогдсон байна. Мөн үений гэмтлийн үед болон бөөрний үйл ажиллагааг нөхөн сэргээх үйлдэлтэй болох нь судалгааны үр дүнд тогтоогдсон байна. Мөн зарим рашааны химийн шинж чанар, бүтэц, найрлагын судалгааг гадаадын улс орнуудын эрдэмтэд, судлаач нартай хамтран явуулж байна. Үүнд Ж.Бигнал, Б.Батхишиг (2003) нарын Шаргалжуутын халуун рашааны илрэл, химийн шинж чанарын судалгаа харуулж байна.

Эрүүл мэндийн тухай хууль - эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3-р зүйлд “Эмнэлгийн тусламж үйлчилгээ гэдэг нь өвчин эмгэг, гэмтэл бэртэл, хүний биеийн үйл ажиллагааны алдагдлыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухаанд тулгуурлан оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан байдаг.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 247-р тоот тушаалаар хүн амд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор чанар нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг түшиглэсэн сувиллын үзүүлэх тусламж үйлчилгээний журамд сувилуулагчийг илгээх, рашаан сувиллын эмчилгээ сувилгаа, сувилалд эмчлэх, сувилах өвчний жагсаалт болон хориглох эмгэгүүд, сувиллаар сувилуулагчийн түүх хөтлөх болон сувилалд илгээх бичгийн маягтын стандартыг тусгасан байна.

Өнөөгийн байдлаар идэвхитэй үйл ажиллагаан явуулж буй сувиллууд нь MNS 5232:2013 стандартын дагуу рашаан сувиллын чанар аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Хөдөөгийн хүн амын дунд үйлчилгээ явуулж буй сумын эмнэлэгт үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгаагаар (Ч.Чулуунбаатар, 2011) нарын судалгаанд сумын эмнэлгээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 61.6% нь хангалуун, 24.4% нь маш хангалуун гэсэн байна. 2015 оны статистик мэдээгээр 105 сувилал үйл ажиллагаа явуулж тэдгээрээр жилд дунджаар 98489 хүн үйлчлүүлж, рашаан сувилалд нийт 868 ажилчид ажиллаж байгаагаас 117 их эмч, 124 сувилагч болон 667

үйлчилгээний ажилчид ажиллаж байгаа бөгөөд өнөөгийн түвшинд рашаан сувиллын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байрны орчин, нөхцөл, тогтвор суурьшил болон рашаан сувиллаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлсон судалгааны ажил хомс байна.

Мөн “Оргил” рашаан сувиллын дэргэдэх Монголын Үйлдвэрчний Эвлэлийн төв зөвлөл зэргийг түшиглэн үйл ажиллагаа явуулж байсан Рашаан сувиллын удирдах газар татан буугдаж, рашааны тухай хууль хүчингүй болж, Рашаан сувиллыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр дуусч ихэнх рашаан сувиллын газрууд хувьчлагдсан өнөө цаг үед тус сувиллын газрууд хүн амд хүртээмжтэй нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэхийг судалж тодорхойлох нь чухал байна. Ялангуяа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед Улсын чанартай рашаан сувилал хэмээн нэрлэгдэж байсан, үйл ажиллагаа хүчин чадал, орны тоо ихтэй ард иргэд олноор үйлчлүүлдэг рашаан сувиллын газруудын стандартын хэрэгжилт, орчин нөхцөл, эмч, эмнэлгийн ажилчдын болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах ажил нэн чухал шаардлагатай байна.

Судалгааны ажлын зорилго: Байгалийн рашааны орд газрыг түшиглэн үйл ажиллагаа явуулж буй сувиллын тусламж үйлчилгээний өнөөгийн байдлыг судлах.

Судалгааны ажлын зорилт

1. Сувиллын өнөөгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг судлах
2. Сувилалд ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдийн тогтвор суурьшил болон ажиллах орчин, нөхцлийг судлах
3. Сувиллаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг дескриптив болон агшингийн судалгааны загварыг ашиглан Баянхонгор аймгийн Шаргалжуут, Завхан аймгийн Отгонтэнгэр, Өвөрхангай аймгийн Хужирт, Хэнтий аймгийн Аварга тосон, Төв аймгийн Өвөр Жанчивлан, Улаанбаатар хотын Оргил рашаан сувиллыг түшиглэн 2016 оны 06 сараас 2017 оны 06 сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Судалгааг энгийн санамсаргүй түүврийн аргаар нийт 30 эмч, мэргэжилтнүүд болон, 150 үйлчлүүлэгчдийг түүвэрлэсэн ба урьдчилсан боловсруулсан асуумжийн аргаар мэдээ, материал цуглуулсан.

Судалгааны ажлын үр дүнгийн боловсруулалтыг SPSS 17.0 программ дээр статистик болон нарийвчилсан статистик аргуудыг ашиглан тоон мэдээллийн хувьд дундажын тухай таамаглал шалгах Т-тестийн арга, хувиар илэрхийлэгдсэн мэдээллийн хувьд Пирсоны Хи квадрат тестийн аргыг тус тус ашигласан. Р утга 0.05-с бага үед статистик үнэн магадтай байхаар тооцов. Сувиллын тусламж үйлчилгээний байдлыг SWOT шинжилгээний аргаар тооцов.

Судалгааны ажлын үр дүн: Сувиллуудын үйл ажиллагааны стандарт хэрэгжилт 94.7% сайн байна. Сувиллын эмч, мэргэжилтнүүдийн 60.0% нь ажиллах орчин нөхцөлдөө сайн гэсэн үнэлгээ өгсөн хэдий ч 36.7% нь 1-3 жил ажилласан тогтвор суурьшил муутай байсан. Мөн 60.0% нь ажлын байрны үнэлэмж бага гэж хариулсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт сувиллаар үйлчлүүлэгчдийн 78.7% эмч нарын харьцаа, хандлага сайн, 70% нь сувилагч нарын харьцаа хандлага сайн гэж үнэлсэн бөгөөд 51.3% нь хоолны амт, чанар дунд, 31.3% нь өрөөний дулаан дунд, 26.0% нь усны хангамж дунд гэж хариулсан байна. Мөн нийт үйлчлүүлэгчдийн 18.7% нь рашаан сувиллаар үйлчлүүлэхдээ ямар нэгэн бэрхшээл тулгардаг гэж хариулсан бөгөөд уг сувиллаар үйлчлүүлэхдээ мэдээллийг дам яриагаар сонсож үйлчлүүлдэг энэ хугацаандаа рашааныхаа талаар сургалт, сурталчилгаанд хамрагддаггүй гэсэн байна.

Судалгааны ажлын дүгнэлт:

1. Сувиллуудын бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 94.7% байгаа хэдий ч сувиллын үйл ажиллагаанд эмийн эмчилгээ, яаралтай тусламжийн тоног төхөөрөмж болон оношилгооны багаж тоног төхөөрөмж дутагдалтай байна.
2. Судалгаанд хамрагдсан эмч мэргэжилтнүүдийн 60.0% нь ажиллах орчиндоо сайн гэсэн үнэлгээ өгсөн хэдий ч рашаан сувиллын эмч, мэргэжилтнүүдийн тогтвор суурьшил муу байна.
3. Судалгаанд хамрагдсан сувиллаар үйлчлүүлэгчдийн 74.3% нь сэтгэл ханамжтай байгаа боловч 76.0% нь рашаан сувиллын талаар мэдээлэл дутмаг, үйлчлүүлж буй рашаан сувиллын талаарх сургалтанд хамрагдаагүй байна.

Түлхүүр үг: Сувилал, тусламж үйлчилгээ, сэтгэл ханамж

SUMMARY

CURRENT STATE OF SANATORIUM HEALTH CARE AND SERVICE IN MONGOLIA

Introduction: According to the statistics of the Center for Health Development, 55359 customers in 2011, 63240 in 2012, 90801 in 2013, 85225 in 2014 and 82996 in 2015 patronized in the sanatoriums. The number of sanatoriums is 67 in 2011, 100 in 2012, 71 in 2013, 104 in 2014 and 105 in 2015. This shows that the number of sanatoriums and their demand for customers are increasing.

In recent years, global trends have focused on the development of post-rehabilitation and health tourism. Therefore, the demand for rehabilitation service is increasing in most countries based on sanatoria and social service.

In Mongolia, Even from 1921, according to the geographical and geological trips, there were established specific aims for studying some of the springs spots. Since the 1960s, in the framework of specific purpose and programs, the applied studies were broadened; Moreover, they developed the classification and regional schema and carried out some studies on the expanding the spots and opening the health resorts. In accordance with the National programs on Spring Sanatorium Development (implemented by Mongolian government) in 1994-2002 and 2002-2010, there were pointed out to define some spring water structure and composition in details, to passport the springs spots, study and determine the regional spring sources, approve their utilization and protection rules.

Our researchers have conducted clinical trials of mineral water from a scientific point of view. Which include, according to the study by Yadamsuren.Ts and Tseveendorj.D, it was found that the water and the clay of Avarga toson lake cure certain skin diseases. On the authority of Zorigtbaatar (2011), "The Clinical trial study on the response of Otgontenger Mineral water treatment", has been confirmed that can reduce to damage of gastric mucosal and liver cells. Also, it has been defined that Otgontenger mineral water improves kidney function and joint function due to trauma. In addition, chemical properties, structure and ingredients of some mineral springs are being studied with scientist and researchers from overseas. A study of Shargaljuut hot spring and its chemical properties carried out by Bignal.J and Batkhishig.B, is showed (2003).

Currently, the sanatoriums are provide services to ensure quality and safety in accordance with MNS 5232:2013. The Law on Health- Article 3 of the Law on Medical Services that states: "The medical service is a comprehensive set of diagnosis, treatment, nursing, palliative care, and rehabilitation of illnesses, injuries and loss of human physical activity based on modern and traditional medical science.

According to the Minister of Health Order #247 in 2012, to improve quality and accessibility of rehabilitaion services for the popultaion, sanatoriums with mineral water, mud, and other natural factors service had been determined by sanitary care regulation, including, to send customer, care of mineral sanitorium, to treat in mineral sanitorium, list of nursing illnesses, contraindicated disorders, and standard forms of writing a record and sending clients. However, there is infufficient data on quality and safety standards for the sanatorium service, implementation of (management structure, organization, supportive activity, sanitation and hygiene) and satisfication survey on doctors, health care professionals and clients. Therefore, we have decided to study the current status of Mineral Sanatorium Service.

Purpose: To study current state of sanatorium services based on the natural mineral source

Goals:

1. Evaluate the service delivery standards.
2. Define the working environment and conditions of the resorts.
3. Estimate the customer satisfaction.

Materials and Methods: From June 2016 to February 2017 we conducted the descriptive cross-sectional study in the following resorts of Mongolian provinces: Shargaljuut – Bayankhngor, Otgontenger – Zavkhan, Khujirt – Uvurkhangai, Avarga toson – Khentii, Uvur Janchivlan – Tuv, Orgil – Ulaanbaatar.

The study was carried out among the 30 physicians and 150 customers, who were randomly selected. We used the previously prepared satisfaction survey to collect the materials.

The study results were developed by SPSS 17.0 program. The T-test and Pearson's chi-square test were used for the quantity data average probability and percentage, respectively. We hypothesized the P value to be statistically significant ($p < 0.05$). The health resort service delivery was assessed using SWOT.